

Суралцагчийн эрүүл мэндийн асуудал хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Пүрэвсүрэн Жавзандолгор

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. СУРАЛЦАГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ, СТРАТЕГИ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ							
1	Суралцагчийн эрүүл мэндийн чиглэлээр бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд үйл ажиллагааны чиглэлийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллах	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо Хэрэгжилтийн хувь	2	2	Эрүүл аюулгүй сургууль арга хэмжээний төлөвлөгөө, Эрүүл шүд арга хэмжээний төлөвлөгөө, сургуульд суурилсан эрүүл мэндийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр төлөвлөгөөг 2 сайдын хамтарсан тушаалаар батлуулан 21 аймгийн БГ, 9 дүүргийн БХ-т хүргүүлэн Суралцагчийн эрүүл мэнд ба “Эрүүл аюулгүй сургууль” арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулах цахим агуулгыг боловсруулан үндсэн сургалтын цахим талбараар 4610 багш, удирдах ажилтанд хүргэж ажиллав. Мөн “Суралцагчийн хөгжил,	2-р сар, 3-р сар, 6-р сар, 9-р сар	Өөрийн үнэлгээ: 100%

					төлөвшил, хамгаалал, аюулгүй байдлыг хангахад арга зүйн дэмжлэг үзүүлэх” зорилгоор Төв, Завхан, Ховд аймгийн боловсролын газрын мэргэжилтнүүд, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн захирал, эрхлэгч, менежер, арга зүйч, эмч, нийгмийн ажилтан нарын төлөөлөл 180 оролцогч, Дотуур байрын багш нарын “Мэдээлэл солилцох уулзалт”-аар 417 дотуур байрын багш нарт “Эрүүл аюулгүй сургууль” арга хэмжээний төлөвлөөг хэрэгжүүлэхэд суралцагчийн эрүүл мэнд, сэтгэл зүй, сургуулийн гадаад, дотоод орчин, хүүхэд хамгаалал, хөгжил зэргийг ханган ажиллах зөвлөмж, чиглэлийг өгч ажиллалаа. хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хавсралт: 3 файл		
2	Суралцагчийн эрүүл мэнд, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн боловсролын чиглэлээр гарсан дүрэм, журамд нийцсэн зөвлөмж боловсруулан нэгжид хүргүүлж хэрэгжилтийг хангах	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	3	3	ЭМЯ, ХӨСҮТ, НЭМҮТ-тэй хамтран цаг үеийн зөвлөмжийг хүргүүлэн шаардлагатай нөхцөл байдлын үед Эрүүл мэндийн чиглэл 2 удаагийн цахим хурлыг БГ-ын дарга, холбогдох мэргэжилтнүүдэд зохион байгуулж, мэдээлэл солилцох уулзалтаар 5 удаагийн мэдээлэл хийж,	2-р сар, 4-р сар, 6-р сар, 8-р сар, 10-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 90%

					албан бичгээр болон албан имэйлээр 20 зөвлөмж, мэдээлэл хүргүүлэн ажилласан.		
3	Хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр сургууль, цэцэрлэгийн эмч нарт зөвлөн туслах	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	6	3	1-р ангийн хүүхдийн зүрх, нүд, шүдний эрт илрүүлэг үзлэгийн зохион байгуулалтын хүрээнд нэгж дээр зөвлөн туслах ажлаар ЕБ-ын 84, 121, 79, 75, 24, 70 дугаар сургуулийн эмч нарт ажлын байран дээр, эмч нарын хамтын ажиллагааг дэмжиж, чадавхжуулах зорилгоор Ховд, Төв аймгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн эмч нарт туршлага судлах, уулзалт сургалтаар зөвлөн тусалж ажиллав.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100%

1.2. СУРАЛЦАГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, ДҮРЭМ, ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨР, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДТОЙ ХАМТРАН АЖИЛЛАХ

4	Хүүхдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр нийслэл, орон нутгийн мэргэжилтнүүд, сургууль, цэцэрлэгийн эмч нарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	6	5	НБГ, НЭМГ-тай хамтран нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын эмч нарт II улирлын хичээл эхэлж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн чиглэлээр хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааны зохион байгуулалт, холбогдох тушаал, журмын танилцуулга, чиглэл өгөх сургалтыг 2025 оны 01 сарын 31-ний өдөр зохион байгуулж Боловсролын сайдын 2024	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100%
---	--	--------------------------------	---	---	--	---	----------------------

				оны 12 сарын 09-ний өдрийн "Зардал батлах тухай" А/234 дугаар тушаалын дагуу нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын 50 сургуульд Нүдний эмгэгийн үзлэгт шаардагдах харааны хэрэглэгдэхүүн худалдан авах ажиллагааг Инвомед трейд ХХК-тай хамтран зохион байгуулж сургуулиудын эмч нарт хүлээлгэн өгсөн. "Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинжуулалтын талаарх давтан сургалт"-ийг 21 аймгийн ЭМГ-ын НЭМХ-ийн орлогч дарга, дархлаажуулалт, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүй, мэдээлэл сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, хүйтэн хэлхээ хариуцсан мэргэжилтэн, Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүд, хүүхдийн эмч, Боловсролын газрын асуудал хариуцсан мэргэжилтэн нарын нийт 105 оролцогч, Суралцагчийн эрүүл мэнд ба “Эрүүл аюулгүй сургууль” арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулах цахим агуулгыг боловсруулан үндсэн сургалтын цахим талбараар 4610 багш, удирдах ажилтанд хүргэж ажиллав. Мөн “Суралцагчийн хөгжил,		
--	--	--	--	--	--	--

					төлөвшил, хамгаалал, аюулгүй байдлыг хангахад арга зүйн дэмжлэг үзүүлэх” зорилгоор Төв, Завхан, Ховд аймгийн боловсролын газрын мэргэжилтнүүд, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн захирал, эрхлэгч, менежер, арга зүйч, эмч, нийгмийн ажилтан нарын төлөөлөл 180 оролцогч, Дотуур байрын багш нарын “Мэдээлэл солилцох уулзалт”-аар 417 дотуур байрын багш нарт “Эрүүл аюулгүй сургууль” арга хэмжээний төлөвлөөг хэрэгжүүлэхэд суралцагчийн эрүүл мэнд, сэтгэл зүй, сургуулийн гадаад, дотоод орчин, хүүхэд хамгаалал, хөгжил зэргийг ханган ажиллах зөвлөмж, чиглэлийг нийт 5207 багш, удирдах болон бусад ажилтанд хүргэн ажиллалаа. Хавсралт: 2 файл		
5	Сургууль, цэцэрлэгийн эмч нарын чадавхыг бэхжүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт, үйл ажиллагааны тоо Сургалтад оролцогчдын тоо	6	4	2024-2025 оны хичээлийн жилд Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан “Удирдамж батлах тухай” А/413, А/151 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангийн суралцагчдад нүд, шүд, зүрхний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулах	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100%

					ажлын хүрээнд нийслэлийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 372 сургуулийн эмч, нийгмийн ажилтан нарыг “Хүүхдийн хараа шалгах аргачлал”-ын сургалтыг зохион байгуулж шуурхай мэдээлэл хүргэх зорилгоор 3 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж 10 удаа албан бичиг, имэйлээр мэдээлэл хүргэж зохион байгуулалтыг ханган ажиллав. Улаанбурхан, Менинкоккт халдвараас сэргийлэх цахим сургалтыг ЕБС-ийн 4500 удирдлага, эмч нарт зохион байгуулсан. Ховд аймгийн Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн эмч нарын хамтын ажиллагааг дэмжиж, чадавхжуулах зорилгоор Улаанбаатар хотноо “Туршлага судлах, сургалт, үйл ажиллагаа”-г зохион байгууллаа. Тус сургалт, үйл ажиллагааны хүрээнд Багшийн эрүүл мэндийг дэмжих төв, Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 14, 21-р сургууль, Сонгинохайрхан дүүргийн 113, 117 дугаар цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ, эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаатай танилцаж,		
--	--	--	--	--	--	--	--

					сайн туршлагаа солилцон цаашдын хамтын ажиллагаа болон тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцлоо. Мөн эмч нар “Боловсролын салбар дахь эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаа”, “Эмч нарын мэргэжлийн хөгжлийн бүлэг бүрдүүлэн ажиллах чиглэл”, “Эмийн зохистой хэрэглээ, мөрдөгдөж буй стандартууд”, “Улаанбурхан өвчний шинж тэмдэг, урьдчилан сэргийлэлт, авах арга хэмжээ”, “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний эрүүл ахуй, орчныг сайжруулах, хяналт тавих арга зүй”, “Хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх нь” зэрэг сэдвийн хүрээнд мэдлэгээ дээшлүүлж хамтарч ажиллалаа.		
6	Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн боловсролын чиглэлээр төрийн болон төрийн бус, мэргэжлийн байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх	Хамтран ажилласан байгууллагын тоо Зохион байгуулсан үйл ажиллагаа /тоо/	6	4	Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн “Нээлттэй хором” нэвтрүүлэгийн "Томуу томуу төст өвчний нөхцөл байдал, хариу арга хэмжээ" хэлэлцүүлэг, "Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар" өгсөн чиглэлээр, НҮБ-ын Хүүхдийн сан, Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжих гэж буй "Сурагчийн эрүүл	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100%

				мэндийн дэвтэр" боловсруулах ажлын хэсэг, МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдах "Амны хөндийн эрүүл мэндийн үндэсний зөвлөгөөн"- зохион байгуулах ажлын хэсэг, Тамхины эсрэг хамтдаа арга хэмжээ, Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй Улаанбурханы нөхцөл байдал, Хүний папиллома вирусын эсрэг дархлаажуулалтыг зохион байгуулах ажлын хэсэг, ЭМЯ-тай 1-р ангийн хүүхдийн эрүүл мэндийн эрт илрүүлэг зохион байгуулах ажлын хэсэг, Эрүүл аюулгүй сургууль арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг, ОРБИС олон улсын байгууллага "Хүүхдийн харааны эрүүл мэнд", Осака хотын "Шүдний эмч нарын холбоо", Ургана брэнд "Хүүхдийн шүдний эрүүл мэнд"-ийн чиглэлээр санамж бичиг байгуулах, НҮБ-ХАС "Ээлтэй сургууль" төсөл, Адра ОУБ-тай Next Gen "Халдварт бус өвчнөөс сэргийлэх" төсөл, Гүүд Нейборс ОУБ-тай "Эрхэм нандин" төсөл зэрэг төр, хувийн хэвшил, олон улсын 12 байгууллагатай 20 чиглэл, арга хэмжээний хүрээнд	
--	--	--	--	---	--

					хамтран ажиллаж байна. Хавсралт: 5 файл		
7	Сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн эрт илрүүлгийн үндэсний тогтолцоог бий болгож сурагчийн нүд, шүд, зүрхний эрүүл мэндийг дэмжих сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт, үйл ажиллагааны тоо Үзлэгт хамрагдсан сурагчийн тоо	Сургалт, үйл ажиллагаа: 5 Үзлэгт хамрагдах сурагчийн тоо: 38000	Сургалт, үйл ажиллагаа: 5 Үзлэгт хамрагдах сурагчийн тоо: 25000	Сургуульд суурилсан эрүүл мэндийн тогтолцоо бүрдүүлэх, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.2.1.14 дэх заалт ЕБС-ийн 6 настай хүүхдийн эрүүл мэндийн эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулах зорилгын дагуу БЯ, ЭМЯ, Орбис ОУБ-тай хамтран "Хараа шалгах аргачлал"-ын 5 удаагийн сургалтад нийслэлийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 300 эмч, орон нутгийн БГ, ЭМГ-ын мэргэжилтнүүд, нүдний эмч нарын төлөөлөл нийт 92 оролцогчийг сургагч багшаар бэлтгэн 21 аймгийн хамтарсан баг аймаг бүрд сургалтаа зохион байгуулж 1-р ангийн нийт 74557 суралцагчийг нүд, шүд, зүрхний урьдчилан сэргийлэх эрт үзлэг хамруулж байгаа бөгөөд үүнээс зүрхний үзлэгт 69396 суралцагч хамрагдаж 12996 суралцагчийг илрүүлж дараагийн шатлалд 7051 суралцагчийг шилжүүлэн, нүдний үзлэгт 60504 суралцагч хамрагдаж 10625 суралцагчийг илрүүлж	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100%

					дараагийн шатлалд 1144 суралцагчийг шилжүүлэн, шүдний үзлэгт 68327 суралцагч хамрагдаж 53942 суралцагчийг илрүүлж дараагийн шатлалд 33773 суралцагчийг шилжүүлэн тус тус эмчлүүлсэн байна. 1-р ангийн суралцагчийн үзлэгт нийт 74557 суралцагч буюу 94% нь хамрагдаж илрүүлсэн 41968 сурагчийг дараагийн шатлалт илгээн эмчлүүлсэн байна. Хавсралт: 2 файл		
8	Суралцагчийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр постер, видео шторк бэлтгэн түгээн дэлгэрүүлэх	Постер, видео шторкны тоо	6	6	“Томуугаас сэргийлье”, “Энгийн дадлаас эрүүл амьдралд”, “Цагийг хэрхэн зохистой өнгөрүүлэх, амьдралын зөв дадал хэвшилтэй болох”, Сурагчдын амралтад зориулан “Цагийг хэрхэн зохистой өнгөрүүлэх, амьдралын зөв дадал хэвшилтэй болох” 3 цуврал зөвлөмжийг БЕГ-ын пейж хуудсаар дамжуулан нийтэлж 10500 хүнд, ХӨСҮТ-тэй хамтын ажиллагааны хүрээнд ЭМЯ, ХӨСҮТ, ДЭМБ хамтран Улаанбурхан өвчний тухай болон өвчлөлийн тархалтаас сэргийлэх, вакцинд хэрхэн хамрагдах талаар 2 видео шторк, 8 постер ЭМЯ, ХӨСҮТ, БЕГ-	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100%

					ийн пэйж хуудсаар нийтэлж 12000 хүнд, ЭМЯ-тай хамтран 24/3 аяны постер, шторк түгээж 1200 хүнд, суралцагчийн эрүүл мэнд, 24/3 Зөв угаа аян, "Эрүүл бяцхан шүд" аян, сургуулийн эмчийн байрны талаарх мэдээллийг тус тус 5240 хүнд хүргэсэн байна.		
9	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд "Жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	Сургалт, үйл ажиллагааны тоо Оролцогчдын тоо	1	1	НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хүний папилома вирусын эсрэг вакцинжуулалтын ажлын хүрээнд дархлаажуулалтын хөтөлбөрийн хэрэгжилт, хүртээмж, хамрагдалтын үед гарах тэгш бус байдлыг бууруулах стратегийг эзэмшүүлэх, жендэрийн харилцан хамаарлыг ойлгоход туслах зорилгоор аймгийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ЭМГ-ын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн нийт 70 оролцогчдод "Эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилтэд жендэрийн тэгш байдлыг хангах нь" сургалтыг зохион байгуулсан бөгөөд 21 аймаг, нийслэлийн төрийн өмчийн 705 ЕБС-ийн захирал, эмч, НА, багш нарын 3525 төлөөллийг оролцуулан	3-р сар, 9-р сар	Өөрийн үнэлгээ: 90%

					сургалтыг зохион байгуулсан. 2025 оны 03 сарын 10-ны өдөр Боловсролын ерөнхий газраас цаг үеийн асуудлаар зохион байгуулагддаг “Мэдээлэл солилцох уулзалт”-аар 21 аймгийн Боловсролын газар, Нийслэлийн боловсролын газар, 9 дүүргийн Болосролын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдэд Хүний эрхийн үндэсний комиссоос ирүүлсэн зөвлөмж, "Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, оношилгоог зохион байгуулахад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зөвлөмж, чиглэл" мэдээллийг тус тус танилцуулан хүргэж ерөнхий боловсролын сургуулиуд суралцагчийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахдаа хүний эрхийг дээдэлсэн хэлбэрээр жендэрийн эрх тэгш байдлыг хангаж, хувь хүний нууцлалыг хангаж хадгалсан, сэтгэл зүйн таатай, ээлтэй орчин бүрдүүлэн зохион байгуулж байгаа бөгөөд өсвөр насны суралцагчийн нас, хүйс, биеийн хөгжлийн онцлогт тохируулсан үзлэгийг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран эмнэлгийн орчинд зохион		
--	--	--	--	--	--	--	--

					байгуулж хэвшсэн. Хавсралт: 2 файл		
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
10	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Хэрэгжилтийн хувь	100	100	ТАХ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг сар, улирлаар гарган бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж ажлын чиг үүргийн хүрээнд 20 албан бичгийг шийдвэрлэж хугацаанд хариуг өгч, 2 тушаал, 2 санамж бичиг боловсруулан батлуулж, 21 аймгийн БГ, 9 дүүргийн БХ-т 16 албан бичгээр чиглэл, зөвлөмж боловсруулж, Мэдээлэл хуваалцах цагаар 5 удаа танилцуулга мэдээлэл, сайдын шуурхайд 5 удаа танилцуулга бэлтгэн тус тус хүргүүлэн ажилласан.	1-р сар, 6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100%
11	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль,	Хэрэгжилтийн хувь	100	100	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль,	3-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100%

	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх				Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: 1. Архив, Албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж 2024 оны архивын 1 нэгжийг бүрдүүлэн хүлээлгэн өгсөн 2. Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Ажлын чиг үүргийн дагуу уулзалт, зөвлөгөөн, сургалтад хамрагдах	Хамрагдсан сургалт, үйл ажиллагааны тоо	5	5	Нийгмийн сэтгэл зүйн тулгамдсан асуудал үндэсний зөвлөгөөн, “Эрүүл шүд-Эрүүл ирээдүй” нүд ам судлалын үндэсний II зөвлөгөөн, “HPV дархлаажуулалтын дүгнэлт” хэлэлцүүлэг, “Дотуур байрын орчны НҮБ-ХАС-ийн Хэрэгжүүлэгч түнш байгууллагыг чадавхжуулах сургалт, НҮБ-ХАС "Технологи ашиглан үйлдэгдэж буй Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй театрын арга, техникийг ашиглан тэмцэх нь" сургагч багш бэлтгэх 2 өдрийн сургалтад хамрагдав.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн эрүүл мэндийн асуудал хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Пүрэвсүрэн Жавзандолгор /...../

Огноо: